

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021-01-28

Тендер шалгаруулалтын нэр: БАГАЖ ТЕХНИК ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ

Тендер шалгаруулалтын дугаар: УБЕГ/202112003

Улсын бүртгэлийн ерөнхий газар эрх бүхий тендерт оролцогчдоос "Багаж техник хэрэгсэл" –г нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна. Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: 2019,2020 оны борлуулалтын орлогын дундаж нь санал болгож байгаа үнийн дүнгийн 60 хувьтай тэнцүү буюу түүнээс дээш байна.
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож байгаа үнийн дүнгийн 50 хувьтай тэнцүү буюу түүнээс дээш байх шаардлагатай.
3. Ижил төстэй гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2019, 2020/ байна.
4. Тендерийн баталгааны дүн: 1'500'000 (нэг сая таван зуун мянга) төгрөг.
5. Цахим тендерийн баталгааг цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар гаргуулна.
6. Тендерийг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 10 цаг 50 минутад Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйлчилгээний нэгдүгээр байрны 4 давхарт 411 тоот өрөөнд нээнэ.
7. Гадаадын этгээд тендерт оролцох эрхтэй.
8. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээлэлтэй холбоотой тодруулгыг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Цагдаагийн гудамж 206, Улсын бүртгэлийн
ерөнхий газрын 1 дүгээр байр 4 давхар 406 тоот
О.Тунгалаг Утас: 77771891-1

